



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 366

Улаанбаатар хот

“Бодь даатгал” ХХК-д дүрмийн сан  
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ  
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг “Бодь даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгч болох иргэн Л.Болдхуягийн 350,000,000.0 /гурван зуун тавин сая/ төгрөг, “Бодь Интернэшнл” ХХК-иас 150,000,000.0 /нэг зуун тавин сая/ төгрөг, нийт 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Л.Болдхуяг	1,050,380,400.0	350,000,000.0	1,400,380,400.0	70%
2	“Бодь Интернэшнл” ХХК	450,162,600.0	150,000,000.0	600,162,600.0	30%
	Нийт	1,500,543,000.0	500,000,000.0	2,000,543,000.0	100.0%

001905

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Бодь даатгал” ХХК /С.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН